“хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж гэрээ байгуулах эрх олгоно.

40. Гүйцэтгэлийн баталгаа

40.1. ТӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч нь гэрээний үнийн 5 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

40.2. Гүйцэтгэлийн баталгаа нь ТШЗ-ны 23.3-т заасан хэлбэрээр байж болох ба гадаадын этгээдээс гаргуулах бол ТШЗ-ны 23.4-т заасан шаардлагыг хангасан байна.

40.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

41. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

41.1. Захиалагч ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, шалгарсан тендерт оролцогчид хүргүүлнэ.

41.2. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ. Захиалагчийн тогтоох энэ хугацаа нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтсан байна.

41.3. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.2-т заасан хугацааны дотор гэрээг зохих ёсоор баталгаажуулж, гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн бол захиалагч гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

41.4. ТШЗ-ны 41.3-т заасан захиалагчийн үүрэг нь төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад эрх бүхий этгээд, эсхүл шүүхээс гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуульд зааснаар хүчингүй болгосон, эсхүл хэрэгжилтийг түдгэлзүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

Ё. БУСАД

42. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол

42.1. Тендерт оролцогч тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хууль тогтоомжийн дагуу гаргана.

43. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт

43.1. ТШЗ-ны 1.1-д заасан тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТӨХ болон тендерийн урилгад заана.

43.2. Захиалагч ТШЗ-ны 43.1-д заасны дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтад энэ тендерийн баримт бичгээс гадна “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-д заасан нөхцөлийг мөрдөнө.

43.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалтаар худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахгүй.

43.4. Худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилж, төсөвт өртгийг ТШЗ-ны 2.1-т зааснаас өөрөөр баталсан бол урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгоно.

43.5. ТШЗ-ны 43.4-т зааснаар гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосонтой холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч хариуцна.

44. Тендер шалгаруулалтын мэдээллийг нийтлэх

44.1. Тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу цахим системээр ил болгоно.

44.2. Захиалагч нээлтийн тэмдэглэл, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд олон нийтэд ил тод мэдээлнэ.

II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Санамж

Захиалагч худалдан авах барааны онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн бараа нийлүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн албан хаагчдын нормын дүрэмт хувцас
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ШШҮХ202112001
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц 1- Албаны өвөл, зуны малгай Багц 2- Савхин хүрэм Багц 3- Өдөр тутмын цамц /урт, богино ханцуйтай/ Багц 4- Захгүй цамц /футболка/ Багц 5- Албаны өвлийн түрийтэй гутал Багц 6- Тэлээ Багц 7- Зангиа Багц 8- Ноосон ороолт Багц 9- Дан өмд Багц 10- Пүүзэн гутал Багц 11- Савхин бээлий Багц 12- Шинжээчийн цүнх /ком/ Багц 13- Усны гутал /урт/
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: 1-12 дугаар багцыг дотоодоос авах боломжтой.
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн 508,518,900 /Таван зуун найман сая таван зуун арван найман мянга есөн зуун төгрөг/ төгрөгийн урсгал зардал.
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 477,018,900 /Дөрвөн зуун далан долоон сая арван найман мянга есөн зуун төгрөг/ Багц 1- Албаны өвөл, зуны малгай- 78,099,500 /Далан найман сая ерөн есөн мянга таван зуун төгрөг/ Багц 2- Савхин хүрэм- 44,250,000 /Дөчин дөрвөн сая хоёр зуун тавин мянган төгрөг/ Багц 3- Өдөр тутмын цамц /урт, богино ханцуйтай/-63,000,000 /Жаран гурван сая/ Багц 4- Захгүй цамц /футболка/ -17,500,000 /Арван долоон сая таван зуун мянган төгрөг/ Багц 5- Албаны өвлийн түрийтэй гутал- 86,000,000 /Наян зургаан сая/ Багц 6- Тэлээ -24,500,000 /Хорин дөрвөн сая таван зуун мянган төгрөг/ Багц 7- Занги -15,050,000 / Арван таван сая тавин мянган төгрөг/ Багц 8- Ноосон ороолт - 21,000,000 /Хорин нэгэн сая/ Багц 9- Дан өмд -22,768,900 /Хорин хоёр сая долоон зуун жаран найман мянга есөн зуун төгрөг/ Багц 10- Пүүзэн гутал -45,500,000 /Дөчин таван сая таван зуун мянган төгрөг/ Багц 11- Савхин бээлий -12,600,000 /Арван хоёр сая зургаан зуун мянган төгрөг/ Багц 12- Шинжээчийн цүнх /ком/ - 41,750,500 /Дөчин нэгэн сая долоон зуун тавин мянга таван зуун төгрөг/ Багц 13- Усны гутал /урт/ - 5,000,000 /таван сая төгрөг/
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 9.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 308 тоот

	Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 1 хороо Энхтайвны өргөн чөлөө ШШҮХ-ийн өөрийн байр Утасны дугаар: 51-266333 Цахим шуудангийн хаяг: www.tender.gov.mn
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 13.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 16.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 18.2	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
ТШЗ 18.2.5	Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: “Шаардана” <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх, 2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг ирүүлэх. 3. Харьяа дүүргийн нийгмийн даатгалын газар, хэлтсээс шимтгэл төлөлтийн өргүйг тодорхойлсон тодорхойлолт ирүүлэх 4. Харилцагч банкны тодорхойлолт /Хугацаа хэтэрсэн өргүй тухай/ 5. Татварын өргүй байх /www.tender.gov.mn/-ээс хянан үзэхэд татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг ирүүлэх. 6. Валютын ханшнаас гарах өөрчлөлтийг тухайн тендерт оролцогч бие даан хариуцах талаарх тодорхойлолтыг албан бичгээр ирүүлэх. 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас өр төлбөргүйг тодорхойлсон тодорхойлолтыг тендер зарласан өдрөөс хойших байдлаар гаргаж ирүүлэх. 8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-д заасан тодорхойлолтыг тендер зарласан өдрөөс хойш байдлаар цахим лавлагаанаас үзнэ. 9. 2020, 2021 оны санхүүгийн тайланг (www.e-balance.mof.gov.mn, www.tender.gov.mn) цахим мэдээллийн системээс авахад татгалзах зүйлгүй албан мэдүүлэг ирүүлнэ. 10. Тендерийн баримт бичгийн ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн албан мэдэгдэл ирүүлэх.
ТШЗ 18.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2020, 2021 оны санхүүгийн тайланг (www.tender.gov.mn , e-balance) цахим мэдээллийн системээс хянан үзнэ.
ТШЗ 18.6	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Сүүлийн 2 жилийн хугацаанд санал болгож буй үнийн дүнгээс багагүй, ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх,
ТШЗ 18.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Шаардахгүй
ТШЗ 18.6.3	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: Шаардахгүй
ТШЗ 18.6.4	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: Шаардлагатай: 2020, 2021 онуудад ижил төстэй нийлүүлсэн барааны үнийн дүнтэй жагсаалтыг ирүүлэх.
ТШЗ 18.6.7	Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана <ul style="list-style-type: none"> • Эсгүүрийн хэсэгчилсэн болон нарийвчилсан огтолгооны машин • Ердийн шулуун оёдлын машин

	<ul style="list-style-type: none"> • Хос оёсны машин • Хэрээсний 3-5 утастай машин • Далд оёсны машин • Савхин бүтээгдэхүүн оёх зориулалтын машин • Гутлын бүрдэл хэсгийг нэгтгэж оёх зориулалтын машин • Гутлын уллагааны зориулалтын машин • Гутлын хэвлүүр • Өвлийн болон саравчтай малгайн хэв
ТШЗ 18.6.8	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: Шаардана</p> <p>Тендерт санал болгосон барааны багц тус бүрт “дээж загвар”-ыг техникийн тодорхойлолтод заасан хэмжээгээр биет хэлбэрээр ирүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> • Тендерт санал болгосон бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нэг бүрчлэн үнэн зөвөөр харьцуулсан тайлбар, хэрэв техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарт дурдаж ирүүлэх. • Тендерт санал болгосон барааны техникийн тодорхойлолтод заасан бүтэц, шинж чанарыг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг ирүүлэх. <p>Хэрэв “дээж загвар”, дагалдах шинжилгээний бичиг” ирүүлээгүй бол тендерээс татгалзана.</p>
ТШЗ 18.7.	Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: Шаардахгүй
ТШЗ 19.5.	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх хугацаа: Шаардахгүй
ТШЗ 20.5.	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 20.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: Incoterms 2020, DDP, Монгол улс Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо ШШҮХ-н байр
ТШЗ 23.1	<p>Тендерийн баталгаа: “Шаардана” 4,770,189 /дөрвөн сая долоон зуун далан мянга нэг зуун наян есөн төгрөг /</p> <p>Багц 1- 780,995 /долоон зуун наян мянга есөн зуун ерэн таван төгрөг/</p> <p>Багц 2- 442,500 /дөрвөн зуун дөчин хоёр мянга таван зуун төгрөг/</p> <p>Багц 3- 630,000 /зургаан зуун гучин мянган төгрөг/</p> <p>Багц 4- 175,000 /нэг зуун далан таван мянган төгрөг/</p> <p>Багц 5- 860,000 /найман зуун жаран мянган төгрөг/</p> <p>Багц 6- 245,000 /хоёр зуун дөчин таван таван мянган төгрөг/</p> <p>Багц 7- 150,500 /нэг зуун тавин мянга таван зуун төгрөг/</p> <p>Багц 8- 210,000 /хоёр зуун арван мянган төгрөг/</p> <p>Багц 9- 227,689 /хоёр зуун хорин долоон мянга зургаан зуун наян есөн төгрөг/</p> <p>Багц 10- 455,000 /дөрвөн зуун тавин таван мянган төгрөг/</p> <p>Багц 11- 126,000 /нэг зуун хорин зургаан мянган төгрөг/</p> <p>Багц 12- 417,505/дөрвөн зуун арван долоон мянга таван зуун таван төгрөг/</p> <p>Багц 13- 50,000 /тавин мянган төгрөг/</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 24.5.3	<p>ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, нотлох баримт бичиг, 2. Тендерт санал болгосон барааны чанарын баталгааны мэдээлэл

ТШЗ 25.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2022.02.08 Цаг: 10 ⁰⁰ минут.
ТШЗ 27.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Цаг: 10 ⁴⁰ минутад нээнэ. Тендер нээх газрын хаяг: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 309 тоотод нээнэ
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.2	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: Ашиглахгүй
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 40.1	Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: Тийм. Гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцэх гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
Ё. БУСАД	
ТШЗ 43.1	Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: Үгүй

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендер оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч тендер оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар

алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендерт оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

НЭГ:

ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧДЭЭС АВАХ
БОЛОМЖТОЙ БАРААНЫ 1-11 ДҮГЭЭР
БАГЦЫН ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 1 -Албаны саравчтай малгай

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	<p>Барааны зориулалт: Шүүхийн шинжилгээний байгууллагын ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намар, зуны улиралд малгайн тэмдэг, саан сагалдаргыг зүүж өмсөж хэрэглэнэ.</p> <p>Мөрдөх чанар, стандартын шаардлага: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор баталсан 1-01 загвар техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна.</p> <p>Бүтэц: Шинж чанар: Албаны саравчтай малгайн орио, хөвөө, хүрээг 50%-ийн ноос, 50%-ийн полиэстериин холиотой хар хөх өнгөөр хийнэ.</p> <p>Албаны саравчтай малгайн орой хөвөөний нэгтгэсэн хэсэг болон хүрээний дээд ирмэгээр 0.15 см-ын хэмжээтэй улаан өнгийн хавчуургыг жигд гарган, хавчуургын голд зориулалтын олсон утас хавчуулж оёсон байна.</p> <p>Албаны саравчтай малгайн урд цохны өндөр 7 см, оройн урт- 28,5 см, өргөн 26 см, гадна талын хүрээний өндөр 4,5 см, дотор талын хүрээний өндөр 5,5 см-ийн хэмжээтэй хийгдсэн байна.</p> <p>Албаны малгайн дотор талын хүрээний хөлсний хамгаалалтыг хар өнгөтэй хиймэл арьсаар хийх бөгөөд хөлсний хамгаалалтын урд талын хэсэгт нэмэлт даавуун хөлсөвчийг давхар оёсон байна.</p> <p>Албаны малгайн саравчны ирмэгийг 0,7 см-ийн өргөнтэйгээр тусгай зориулалтын машинаар эмжиж оёж бэлтгэсэн байх бөгөөд саравчны хоёр үзүүрээс 2,0 см зайд саан болон хар сагалдарга зүүх зориулалттай шонхортой жижиг товчийг хүрээний доод ирмэгээс дээш 1,0 см-т тогтоож, малгайн тэмдэг зүүх нүхийг урд талын цохыг голлуулан хүрээний дээд ирмэгээс доош 2 см-т гуурсаар нэвт хадаж гаргасан байна.</p> <p>Саравчтай малгайн дотор талын оройн голд 12 см-ийн диаметртэй, хар хөх өнгийн хөлсөвчний хамгаалалтыг дарж оёсон байх бөгөөд хөлсөвчний хамгаалалтын материал нь чийг татахгүй, агаар нэвтрүүлдэг, хөлсийг оройн өнгө материалруу нэвтрүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Албаны саравчтай малгайн урд талын цох, хүрээ, хөвөөний хатуулгыг эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан зориулалтын материалаар хийж, оройн дотор талыг гуурсаар тэлж хэлбэржүүлсэн байна.</p> <p>Албаны саравчтай малгай нь эдэлгээний болон тээвэрлэлтийн явцад хэлбэрээ алдахгүй байх шаардлагатай.</p> <p>Албаны саравчтай малгай нь 6-24 загварын дугаартай мөнгөлөг саарал өнгийн ороосон утсыг 3, 3-аар сүлжиж, 2 эгнээ болон битүүлж сүлжиж хийсэн саан сагалдаргатай байна/малгайн тэмдгийн хамт/. Материалыг итгэмжлэгдсэн лаборатораар</p> <p>Загварт 59 размерийн 1 ширхэг малгай ирүүлнэ. Ирүүлсэн загвар эцсийн бүтээгдэхүүн байна.</p> <p>Эрүүл ахуй, аюулгүйн байдал: Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Баглаа боодол, барааны нэр, шошго: Тээвэрлэхэд тохиромжтой ус чийг гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын дагуу сав баглаа</p>		

	<p>боодлоор боож шошго нь дотор талд харагдахуйцаар байрлах, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг гадна талд нь зүүж нэг бүрчлэн ууталсан байн.</p> <p>Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл: Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч хариуцахгүй. 1 жилийн хугацаанд үйлдвэрийн гэмтэл үүссэн тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж засварлана.</p>		
--	---	--	--

МАЛГАЙ

1 | АЛБАНЫ САРАВЧТАЙ МАЛГАЙ

ЗАГВАРЫН ДУГААР: 1-01

ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:

Албаны саравчтай малгайг цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нар малгайн тэмдэг, саан сагалдаргыг зүүж өдөр тутмын хувцастай өмсөж хэрэглэнэ.



МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР

Албаны саравчтай малгайн орой, хөвөө, хүрээг 50%-ийн ноос, 50%-ийн полиэстериин холиотой хар хөх, цагаан өнгийн даавуугаар хийнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 1- Өвлийн малгай

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	<p>Барааны зориулалт: Шүүхийн шинжилгээний байгууллагын дээд офицер, хурандаа цолтноос бусад ахлах, дунд офицер, ахлагч нар өвлийн улиралд малгайн тэмдэг хадаж өмсөж хэрэглэнэ.</p> <p>Мөрдөх чанар, стандартын шаардлага: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор баталсан загвар техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна.</p> <p>Бүтэц: Шинж чанар: Өвлийн малгайн цох, чих, шилбийг хар хөх өнгийн хиймэл үсээр хийж зориулалтын дулаалгын материалаар доторлосон байна/малгайн тэмдгийн хамт/.</p> <p>Загвар: 57 размерийн 1 ширхэг тендерийн материалын хамт ирүүлнэ, ирүүлсэн загвар эцсийн бүтээгдэхүүн байна.</p> <p>Эрүүл ахуй, аюулгүйн байдал: Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Баглаа боодол, барааны нэр, шошго: Тээвэрлэхэд тохиромжтой ус чийг гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын дагуу сав баглаа боодлоор боож шошго нь дотор талд харагдахуйцаар байрлах, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг гадна талд нь зүүж нэг бүрчлэн ууталсан байн.</p> <p>Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл: Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч хариуцахгүй. 1 жилийн хугацаанд үйлдвэрийн гэмтэл үүссэн тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж засварлана.</p>		

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ


МАЛГАЙ

1 | ӨВЛИЙН МАЛГАЙ

ЗАГВАРЫН ДУГААР: 1-03

ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:

Хиймэл үстэй малгайг цагдаагийн дээд офицер, хурандаа цолтноос бусад ахлах, дунд офицер, ахлагч нар өвлийн улиралд малгайн тэмдгийг хадаж өмсөж хэрэглэнэ.



МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР

Өвлийн малгайн цох, чих, шилбийг хар хөх өнгийн хиймэл үсээр хийж, зориулалтын дулаалгын материалаар доторлосон байна.



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 1- Берет малгай

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	<p>Барааны зориулалт: Шүүхийн шинжилгээний байгууллагын дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намар, зуны улиралд малгайн тэмдэг хадаж өмсөж хэрэглэнэ.</p> <p>Мөрдөх чанар, стандартын шаардлага: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор баталсан 1-04 загвар техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна.</p> <p>Бүтэц: Шинж чанар: Берет малгайг 100 хувийн ноосны холиотой хар хөх өнгийн эсгийг хэвлэж хийнэ/малгайн тэмдгийн хамт/.</p> <p>Загвар: 57 размерийн 1 ширхэг тендерийн материалын хамт ирүүлнэ, ирүүлсэн загвар эцсийн бүтээгдэхүүн байна.</p> <p>Эрүүл ахуй, аюулгүйн байдал: Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Баглаа боодол, барааны нэр, шошго: Тээвэрлэхэд тохиромжтой ус чийг гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын дагуу сав баглаа боодлоор боож шошго нь дотор талд харагдахуйцаар байрлах, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг гадна талд нь зүүж нэг бүрчлэн ууталсан байн.</p> <p>Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл: Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсөн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч хариуцахгүй. 1 жилийн хугацаанд үйлдвэрийн гэмтэл үүссэн тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж засварлана.</p>		

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

МАЛГАЙ

1 | БЕРЕТ МАЛГАЙ

ЗАГВАРЫН ДУГААР: 1-04


ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:

Берет малгайг цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намар, зуны улиралд малгайн тэмдгийг хадаж, өдөр тутмын хувцастай өмсөж хэрэглэнэ.



МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР

Берет малгайг 100%-ийн ноосны холиотой хар хөх өнгийн эсгийг хэвлэж хийнэ.



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 1: Ноосон малгай

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	<p>Барааны зориулалт: Шүүхийн шинжилгээний байгууллагын дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар өвлийн улиралд өмсөж хэрэглэнэ.</p> <p>Мөрдөх чанар, стандартын шаардлага: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 1-06 дугаар загвар, Олон Улсын EN 347 MNS 84 : 2002, MNS 5307 : 2003 стандарт, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна.</p> <p>Бүтэц: Шинж чанар: Ноосон малгай нь үйлдвэрлэлийн нөхцөлд технологийн горимын дагуу боловсруулагдсан хар хөх өнгөтэй 40%-ийн монгол хонины ноос, 60%-ийн акрилын хольцтой ээрмэл утсаар нэхсэн байх бөгөөд сүлжмэл эдлэлийн эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. Ноосон малгай нь хар хөх өнгөтэй сүлжмэл материалаар эргэсэн манжеттай, давхарлан хийсэн байх бөгөөд нэхээсний алдагдалгүй, жигд, хэрэглээнд тэсвэртэй, будгийн тогтворжилт сайтай, амархан гандахгүй, агшиж сунахгүй, ээрмэл утсаар хийсэн байна.</p> <p>Цагдаагийн алба хаагчийн хар хөх ноосон малгайн манжетны дээд ирмэгийн дагуу 4,5 см өргөн, 11,5 см урттай хар хөх даавуун дээр цагаан саарал өнгөөр хатгаж хийсэн "POLICE" бичиглэлийг оёж тогтоосон байна.</p> <p>/Үндсэн материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг хамт ирүүлнэ./</p> <p>Загвар: Ноосон малгайг 1 ширхэг тендерийн материалын хамт ирүүлнэ, ирүүлсэн загвар эцсийн бүтээгдэхүүн байна.</p> <p>Эрүүл ахуй, аюулгүйн байдал: Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Бүтээгдэхүүний зураг:</p> <div data-bbox="549 1346 997 1794" style="text-align: center;"> </div> <p>Баглаа боодол, барааны нэр, шошго: Тээвэрлэхэд тохиромжтой ус чийг гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын дагуу сав баглаа боодлоор боож шошго нь дотор талд харагдахуйцаар байрлах, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг гадна талд нь зүүж нэг бүрчлэн ууталсан байн.</p> <p>Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл: Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч хариуцахгүй. 1 жилийн хугацаанд үйлдвэрийн гэмтэл үүссэн тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж засварлана.</p>		

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


Багц 2- Савхин хүрэм /эрэгтэй загвар/

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	<p>Барааны зориулалт: Шүүхийн шинжилгээний байгууллагын дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар өвлийн улиралд өмсөж хэрэглэнэ.</p> <p>Мөрдөх чанар, стандартын шаардлага: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 2-11 дүгээр загвар, MNS 86: 2002 ,MNS 5177:2002 стандарт, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна.</p> <p>Бүтэц: Шинж чанар: Савхин хүрмийг үйлдвэрлэлийн нөхцөлд технологийн горимын дагуу боловсруулагдсан хар өнгөтэй, өнгө туяаны ялгаагүй уян зөөлөн, биелэг, будгийн тогтоц сайтай, шивээс сорвигүй, өнгө алаглаагүй, 1,2мм зузаантай, 1-р зэрэглэлийн ямааны арьсаар хийх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна.</p> <p>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ/</p> <p>Загвар: 50-3 размерийг 1 ширхгийг материалын хамт ирүүлнэ, ирүүлсэн загвар эцсийн бүтээгдэхүүн байна.</p> <p>Эрүүл ахуй, аюулгүйн байдал: Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Үйлдвэрлэх технологи ажиллагаа: Савхин хүрмийг хар өнгийн 1-р зэрэглэлийн ямааны арьсаар эргэсэн хэвтээ захтай, уулзсан цахилгаан товчлоостой, энгэрийн даруулгатай, далны хөндийрүүлэгчтэй, ташаандаа цахилгаантай 2 хажлагатай халаастай, энгэрт нэр, хувийн дугаарын бичиглэлийг наах зориулалттай хар өнгөтэй зангуутай, ханцуйн үзүүр битүү хагалбартай манжеттай, хормойн хэсэгт резинтэй манжеттай, сойлттой, ташаа нь оёдолд орсон цахилгаантай хагалбартай, энгэрийн дотрын баруун талд 1 хажлагатай, зүүн талд цахилгаантай халаастай, энгэрийн даруулга, мөрдөс тогтоогч, халаасны таг, сойлт, ханцуйн манжетанд хар өнгийн шонхортой кнопон товчтой. Хүрэмний энгэрт нэр, хувийн дугаарын бичиглэлийг наах зориулалттай 2,5смх14см-ийн хэмжээтэй хар өнгөтэй зангуу /эм/-г тус тус голлуулан хадсан байхын зэрэгцээ зангуун товч нь 15-20 удаагийн угаалгад тэсвэртэй, наалдах чадвараа алдаггүй байх шаардлагатай.</p> <p>Савхин хүрэм нь ар тал нь чөлөөт хөдөлгөөнийг хангасан далны хөндийрүүлэгчтэй байх бөгөөд үүнийг дотор талаас нь өргөн резинээр холбож, мөрний хэсэгт 3,5 см х 5,0 см хэмжээтэй бөхөлгөө оёдлыг зургийн дагуу хийсэн байна.</p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">   </div> <p>Савхин хүрэмний ханцуй нь ердийн залгаа, ханцуйн үзүүрт 5,0-н см өргөн манжеттай байх бөгөөд хар өнгөтэй, шонхортой кнопон товчлоостой, ханцуйн үзүүр битүү хагалбартай манжеттай, байх бөгөөд зүүн, баруун талын ханцуйд ханцуйн бэлгэдэл тэмдгийн зангуу /эм/-г 5,0 см-т голлуулан хадсан байх ба зүүн, баруун талын ханцуйд хадах /эр/ зангуутай 8,5 см х 11 см-ийн хэмжээтэй ханцуйн бэлгэдлийг савхин хүрэмтэй хамт ирүүлсэн байна.</p> <p>Савхин хүрэмний нэгтгэсэн хэсгүүд болон жижиг бүрдэл хэсгүүдийг зориулалтын утсаар 0.2-0.7 см /хос оёдол/ чимэг оёдлоор оёж, энгэрийн</p>		

даруулгад 4 ширхэг, мөрдэс тогтоогчид тус бүр 1 ширхэг, энгэрийн ташааны халаасны таганд тус бүр -1 ширхэг, ханцуйн манжетанд тус бүр 1 ширхэг, ташааны хагалбар онооны сойлтод тус бүр 1 ширхэг шонхортой кноп товч /6-24 загварын /-оор товчлогдоно.

Шонхортой кноп товч нь хар өнгөтэй, 17 мм -ийн диаметртэй дугуй хэлбэртэй, толгой суурь тэдгээрийн түгжигч гэсэн 4 иж бүрдэлтэй байна. Шонхортой кнопки толгойг дээш харуулж зориулалтын машинаар эдэлгээний явцад мултарч унахааргүй жигд хадсан байна.

Цахилгаан товч нь хар өнгөтэй даавуун тасамтай, өтгөн шигүү хуванцар шүд /plastic black dense teeth and tape/-тэй, төмөр толгойтой, -15°C-ийн хэмд тэсвэртэй байх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. Цагдаагийн дүрэмт хувцасны цахилгаан товч нь хувцасны бүрдэл хэсэгт хадагдах байрлал, зориулалтаас нь хамааран цахилгааны урт өргөний хэмжээ, толгойн хэлбэр, дээд доод талын төгсгөлүүд нь өөр өөр байх ба энгэрийн цахилгаан товч нь 2



толгойтой, эхлэл, төгсгөлүүд төгсгөлүүд нь задгай /Two way Open-end/ автомат түгжигчтэй, #8 номерын хэмжээтэй, халаасны цахилгаан цахилгаан товч нь 1 толгойтой, эхлэл болон төгсгөл битүү /Open form Close end/, #5 номерын хэмжээтэй, цахилгаан товчны толгойн

татуургад цагдаагийн байгууллагын бэлгэдэл болох "Шонхор" –той эмблемийг хийсэн байна. Савхин хүрэмний цахилгаан товч нь эдэлгээний явцад задарч эвдрэл үүсдэггүй, шүд, толгойн хэсэг нь салж унадаггүй, бөх бат байх шаардлагатай.

Савхин хүрмийг хар өнгийн 100 хувийн полиэстерын холиотой, сарьж нэхээстэй, чөлөөт хөдөлгөөнийг хангасан гөлгөр гадаргуутай, гадаад өнгө үзэмж сайтай,

будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 5 баллаас багагүй, ширмэл дотрын материалаар салдаггүй байхаар дулаалсан байна.

Ширмэл дотор нь 100 г/м² жинтэй сентофонон дулаалгатай байх бөгөөд сентофононыг торгон дотортой тусгай зориулалтын машинаар жигд дулаалгын материалыг гүйлгэж бөөгнөрөхөөргүй гоёлын оёдлоор ширж оёсон байна. Дотрын захны гол болон ташаанд размеров шошгыг хадсан байна.

Баглаа боодол, барааны нэр, шошго: Тээвэрлэхэд тохиромжтой ус чийг гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын дагуу сав баглаа боодлоор боож шошго нь дотор талд харагдахуйцаар байрлах, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг гадна талд нь зүүж нэг бүрчлэн ууталсан байна.

Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл: Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч хариуцахгүй. 1 жилийн хугацаанд үйлдвэрийн гэмтэл үүссэн тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж засварлана.

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

ГАДУУР ХУВЦАС

2 САВХИН ХҮРЭМ

ЗАГВАРЫН ДУГААР: 2-11

ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:

Савхин хүрмийг цагдаагийн дээд офицер, хурандаа цолтноос бусад ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намрын улиралд өдөр тумын хувцастай албаны мөрдэс зүүж өмсөж хэрэглэнэ.



МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР

Савхин хүрмийг хар өнгийн, зөөлөн, торгон, будгын тогтоц сайтай, нэгдүгээр зэрэглэлийн, 1,2 мм-ээс доошгүй зузаантай савхиар хийнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 2- Савхин хүрэм /эмэгтэй/

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	<p>Барааны зориулалт: Шүүхийн шинжилгээний байгууллагын дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намрын улиралд өмсөж хэрэглэнэ.</p> <p>Мөрдөх чанар, стандартын шаардлага: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 2-12 дугаар загвар, MNS 86: 2002 ,MNS 5177:2002 стандарт, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна.</p> <p>Бүтэц: Шинж чанар: Савхин хүрмийг үйлдвэрлэлийн нөхцөлд технологийн горимын дагуу боловсруулагдсан хар өнгөтэй, өнгө туяаны ялгаагүй уян зөөлөн, биелэг, будгийн тогтоц сайтай, шивээс сорвигүй, өнгө алаглаагүй, 1,2 мм зузаантай, 1-р зэрэглэлийн ямааны арьсаар хийх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна.</p> <p>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ/</p> <p>Загвар: 48-3 размерийг 1 ширхгийг материалын хамт ирүүлнэ, ирүүлсэн загвар эцсийн бүтээгдэхүүн байна.</p> <p>Эрүүл ахуй, аюулгүйн байдал: Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Үйлдвэрлэх технологи ажиллагаа: Савхин хүрэм нь эргэсэн зах бартаатай хар өнгөтэй, дан зөрлөгтэй, ар, энгэр нь хөндлөн болон тууш оруулгатай, мөрдэс тогтоогчтой, энгэр нь хөндлөн байрласан 1 хажлагатай тагтай халаастай, ханцуй нь сойлттой, пивор аралтай бүстэй, түдүүлтэй байх бөгөөд энгэр, мөрдэс тогтоогч, ханцуйн сойлт нь эвэр товчоор товчлогддог байна. Савхин хүрэмний товчийг товчилж тайлахад урагдаж ханзрахгүй байх үүднээс хажлага гаргаж оёсон байна.</p> <p>Савхин хүрэмний энгэр нь хөндлөн оруулгатай оруулганы дээд талд нэр, хувийн дугаарын бичиглэлийг наах зориулалттай 2,5см x 14см-ийн хэмжээтэй хар өнгөтэй зангуу /эм/-г тус тус голлуулан хадсан байхын зэрэгцээ зангуун товч нь 15-20 удаагийн угаалгад тэсвэртэй, наалдах чадвараа алдаггүй байх шаардлагатай. Савхин хүрэм нь арын хөндлөн болон тууш оруулгатай байна.</p> <p>Савхин хүрэмний нэгтгэсэн хэсгүүд болон жижиг бүрдэл хэсгүүдийг зориулалтын утсаар 0.2-0.7 см /хос оёдол/ чимэг оёдлоор оёж, энгэрт 4 ширхэг, мөрдэс тогтоогчид тус бүр 1 ширхэг, ханцуйн сойлт тус бүр 1 ширхэг, хар өнгөтэй, дугуй хэлбэртэй, эвэр товчоор товчлогдоно. Эвэр товчийг зориулалтын машинаар хадсан байна.</p> <div style="display: flex; align-items: center; margin-top: 10px;">   <div style="flex-grow: 1;"> <p>Савхин хүрэмний ханцуй нь ердийн залгаа, ханцуйн үзүүрт сойлттой, сойлт нь эвэр товчоор товчлогдох бөгөөд зүүн, баруун талын ханцуйнд ханцуйн бэлгэдэл тэмдгийн зангуу /эм/-г 5,0 см-т голлуулан хадсан байна. Ханцуйн бэлгэдэл тэмдэг нь 8,5:11 см хэмжээтэй хатгамал хийцтэй байна.</p> <p>“Цагдаа” ханцуйн бэлгэдэл тэмдгийн ар талд ханцуйн дээр тогтоох зориулалттай зангуу /эр/-г нааж, хүрээг дагуулан давхар оёж бэлтгэсэн байна.</p> <p>Савхин хүрэмний мөрдэс тогтоогч нь ханцуйн залгаа оёдолд орсон байх ба тогтоогчийн өргөн 4,5 см, урт нь 15 см байна.</p> <p>Савхин хүрмийг 100 хувийн полиэстерын холиотой, сарьж нэхээстэй, чөлөөт</p> </div> </div>		

хөдөлгөөнийг хангасан гөлгөр гадаргуутай, гадаад өнгө үзэмж сайтай, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 5 баллаас багагүй, ширмэл дотрын материалаар салдаггүй байхаар дулаалсан байна. Ширмэл дотор нь 100 г/м² жинтэй сентофонон дулаалгатай байх бөгөөд сентофононыг торгон дотортой тусгай зориулалтын машинаар жигд дулаалгын материалыг гүйлгэж бөөгнөрөхөөргүй гоёлын оёдлоор ширж оёсон байна. Дотрын захны гол болон ташаанд размерын шошгыг хадсан байна. Баглаа боодол, барааны нэр, шошго: Тээвэрлэхэд тохиромжтой ус чийг гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын дагуу сав баглаа боодлоор боож шошго нь дотор талд харагдахуйцаар байрлах, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг гадна талд нь зүүж нэг бүрчлэн ууталсан байн. Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл: Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсэн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч хариуцахгүй. 1 жилийн хугацаанд үйлдвэрийн гэмтэл үүссэн тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж засварлана.

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ
ГАДУУР ХУВЦАС

2 | САВХИН ХҮРЭМ

ЗАГВАРЫН ДУГААР: 2-12

ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:

Савхин хүрмийг цагдаагийн дээд офицер, хурандаа цолтноос бусад ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намрын улиралд өдөр тутмын хувцастай албаны мөрдэс зүүж өмсөж хэрэглэнэ.




МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР

Савхин хүрмийг үйлдвэрлэлийн нөхцөлд технологийн горимын дагуу боловсруулагдсан хар өнгөтэй, өнгө туяаны ялгаагүй уян зөөлөн, биелэг, будгийн тогтоц сайтай нэгдүгээр зэрэглэлийн савхиар хийнэ.

Техникийн тодорхойлолт
Багц 3- Өдөр тутмын цамц /урт ханцуйтай/

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар
1	<p>Барааны зориулалт: Шүүхийн шинжилгээний байгууллагын дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар зун, хавар, намрын улиралд албаны мөрдэс зүүж өдөр тутмын болон албаны өмдтэй, өвлийн улиралд мөрдэсгүйгээр хүрэмний дотор өмсөж хэрэглэнэ.</p> <p>Мөрдөх чанар, стандартын шаардлага: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 3-09-10 дугаар загвар, MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтална.</p> <p>Бүтэц: Шинж чанар: Хар хөх өнгөтэй, цулгуй 45 хувийн хөвөн, 65 хувийн полиэстериин холиотой, 3%-ийн суналттай, үрчийдэггүй, сарж нэхээстэй, торгомсог гадаргуутай, 1м²- ын жин нь 170-180 г/м², хөлсийг гадагшлуулдаг, бүрзийдэггүй, үрчийдэггүй нэмэлт боловсруулалттай, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4-5 баллаас багагүй хөвөн даавуун материалаар хийгдсэн байна.</p> <p>/Захиалагч талаас өнгө материалыг нийлүүлнэ./ Эрүүл ахуй, аюулгүйн байдал: Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай.</p> <p>Үйлдвэрлэх технологи ажиллагаа: Өдөр тутмын цамцыг хар хөх өнгөтэй материалаар эргэсэн суурь захтай, хагас бариу хэлбэртэй, энгэрийн дээд талд тагтай эзлэхүүнтэй ил халаастай, мөрдэс тогтоогчтой, ар нь хөндлөн оруулгатай хормой нь өдөр тутмын өмдний дотуур чихэж өмсөх зориулалттай хийгдсэн байна.</p> <p>Арын хөндлөн оруулгад 6 см өндөртэй 26,5 см урттай "POLICE" бичиглэлийг, ойх /цацруулах / чадвар нь 1м² –д 350 cd-ээс багагүй цацруулагч туузаар хийж гадна ирмэгийг тусгай зориулалтын машинаар хатгасан байна.</p> <p>Өдөр тутмын цамц нь ердийн залгаа, урт ханцуйтай, суганы гурвалжин оруулгатай, оруулгад агаар солилцох нүхийг тусгай зохицуулалтын машинаар хатгаж хийсэн байх ба ханцуй үзүүр нь манжеттай байх бөгөөд ханцуйг нугалж өмсөх зориулалтын сойлттой байна. Сойлт нь 1 ширхэг эвэр товчоор товчлогдоно.</p> <p>Өдөр тутмын хар хөх цамцны зах, халаасны тагны гол, мөрдэс тогтоогч нь хошуу хэлбэртэй, халаасны тагны булан, хормойн үзүүр нь дөрвөлжин хэлбэртэй байна.</p> <p>Өдөр тутмын хар хөх цамцны суурь зах, ил халаасны таг, мөрдэс тогтоогч тус бүр нь 1 ш, энгэр нь 6 ш эвэр товчоор товчлогдоно. Эвэр товч нь хөх өнгөтэй, 13 мм-ийн диаметртэй, дугуй хэлбэртэй, 3 мм-ийн зузаантай, 4 мм- ийн өргөнтэй хүрээг төв хэсэг рүү нь тэгш хэмтэй товойлгон гаргаж, хүрээний өнгөн талд "POLICE" бичиглэл болон цагдаагийн цолны "ТАВАН ХОШУУ" дүрсийг зургийн дагуу гаргасан байх бөгөөд 4 ширхэг нүхтэй байна. Өдөр тутмын хар хөх цамцны суурь зах, ил халаас, халаасны таг, мөрдэс тогтоогч, суганы оруулга, ханцуйн залгаа нь 0,2 см, энгэрийн планка, хормой нь 0,5 см, зах, арын оруулга, ханцуйн үзүүрийн манжет нь хос оёдлоор оёж, товчны нүхийг шулуун хэлбэртэй гаргаж, суга, ташааг тусгай зориулалтын гинжин хатгацтай машинаар битүү ороож хос оёдлоор дарж оёсон байна.</p> <p>Өдөр тутмын хар хөх цамцны зүүн, баруун талын ханцуйнд "Цагдаа" бэлгэдлийг ханцуйн оройноос доош 3,5 см-ийн зайтай голлуулан байрлуулж гадна ирмэгийг тусгай зориулалтын хатгамлын машинаар хатгаж хадсан байна. Цамцны ханцуйн бэлгэдэл тэмдэг нь 8,5:11 см хэмжээтэй нэхмэл хийцтэй байна.</p> <p>Эмэгтэй загварын хар хөх цамц нь хагас бариу хэлбэртэй, энгэр болон арын бүсэлхийн хэсгээр босоо танаастай байх бөгөөд бусад хийц нь дээрх загвартай адил байна.</p>		



	<p>Баглаа боодол, барааны нэр, шошго: Тээвэрлэхэд тохиромжтой ус чийг гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын дагуу сав баглаа боодлоор боож шошго нь дотор талд харагдахуйцаар байрлах, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг гадна талд нь зүүж нэг бүрчлэн ууталсан байн.</p> <p>Гэрээнд тусгагдах онцлог тусгай нөхцөл: Нийлүүлэх хугацаа хэтэрсэн, зөвшөөрсөн материалын загвар өөрчлөгдсөн, стандарт зөрчигдсөн нөхцөлд бүтээгдэхүүнийг хүлээж авахгүй ба үүнээс гарах хохирлыг захиалагч хариуцахгүй. 1 жилийн хугацаанд үйлдвэрийн гэмтэл үүссэн тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж засварлана.</p>		
--	---	--	--

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

ДАН ХУВЦАС

3 || ӨДӨР ТУТМЫН ЦАМЦ /УРТ ХАНЦУЙТАЙ/ ЗАГВАРЫН ДУГААР: 3-09-10

ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:

Урт ханцуйтай хар хөх цамцыг цагдаагийн дээд, ахлах, дунд, офицер, ахлагч нар өдөр тутмын дүрэмт хувцастай албаны мөрдэс, зангиа зүүж өмсөж хэрэглэнэ.



МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР

Урт ханцуйтай хар хөх цамцыг 45%-ийн хөвөн, 65%-ийн полиэстериин холиотой, 3%-ийн суналттай, хар хөх өнгийн даавуугаар хийнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 3- Өдөр тутмын цамц /богино ханцуйтай/

	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникин тодорхойлолт	Тайлбар
